- Орон нутгийн өмч 4,427.9 сая төгрөгөөр буурахад "Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 3,065.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 4,178.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №9 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	242.0	476.5	234.5	96.9
Татварын бус орлого	3,004.2	-134.9	-3,139.1	-89.5
Тусламж санхүүжилтийн орлого	3,997.8	881.2	-3,116.6	-77.9
Нийт дүн	7,243.9	1,222.8	-6,021.1	-83.1

Эх сурвалж: Их-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт орлогын дүн буурахад гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын тайлан улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, санхүүжилтийн орлого буурсан нь нөлөөлсөн байна. Татварын орлого өссөн нь орон нутгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна. Их-Уул дулаан ХХК-ийн борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үйл ажиллагааны зардалд оруулж нэгтгээгүй татварын бус орлогод борлуулалтын орлогоос хасаж нэгтгэсэн ба төсвийн байгууллагад борлуулалт хийсэн 403.4 сая төгрөгийн борлуулалтын орлогыг устгахад татварын бус орлогыг сөрөг утгатай болсон байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,843.1 сая төгрөгийн орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 7,355.8 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №10: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	4,127.7	1,156.6	-2,971.1	-72.0
Үйл ажиллагааны бус зардал	65.9	4,356.1	4,290.2	6510.2
Нийт дүн	4,193.6	5,512.7	1,319.1	31.5

Эх сурвалж: Их-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт зардлын дүн өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалыг шилжүүлэхдээ үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын хоорондын тооцоогоор 1,843.1 сая төгрөгийн зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Их-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 06 дүгээр тогтоолоор сумын төсвийн орлогын эх үүсвэрийг 1,687.2 сая төгрөгөөр, зарлагыг 1,687.2 сая төгрөгөөр баталсан бөгөөд төсвийн жилийн явцад 2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2.5 төгрөгөөр нэмж төсвийн тодотгол, зохицуулалт хийж төсвийн орлого зарлагыг 1,689.7 сая төгрөгөөр тодотгон баталсан байна. Аймгийн засаг даргын 2022 оны 12 сарын 01-ний өдрийн А/429 дүгээр захирамжаар 25,6 сая төгрөгийн төсөвт хасах зохицуулалт хийж 1,664.1 сая төгрөг болсон байна.

Нийт зардлын 409.7 сая төгрөгийг орон нутгийн орлогоос, 130.2 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 743.5 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 306.6 сая төгрөгийг давсан орлого дансны үлдэгдлээс, 61.5 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлогоос, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 12.6 сая төгрөг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Их-Уул сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2.5 сая төгрөгөөр нэмж төсвийн тодотгол, зохицуулалт хийж төсвийн орлого зарлагыг 1,689.7 сая төгрөгөөр тодотгон баталсан байна. Аймгийн засаг даргын 2022 оны 12 сарын 01-ний өдрийн А/429 дүгээр захирамжаар 25,6 сая төгрөгийн төсөвт хасах зохицуулалт хийж 1,664.1 сая төгрөг болсон байна.

2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 12 дугаар дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар аймгийн төсвөөс олгох санхүү дэмжлэгээс санхүүжих 83.3 сая төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 769.1 сая төгрөгөөр баталсан байна. Хасах тодотгол хийсэн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагад ажиллагсдын цалинг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой байна. Аймгийн засаг даргын захирамжаар 25.6 сая төгрөгийн зохицуулалтыг Ерөнхий боловсролын сургуулийн түлш халаалтын зардлаас хасах тодотгол хийсэн байна.

Гүйцэтгэлээр мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 113.5 сая төгрөг дээр орон нутгийн төсвийн санхүүжилт 1,346.4 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 93.8 сая төгрөг, хүүгийн эргэн төлөлт 5.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 130.2 сая төгрөгийн санхүүжилтийн орлого орж, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 4.6 сая төгрөг, 1,511.5 сая төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 46.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 135.9 сая төгрөг байна. Төсвийн орлого бүрдүүлэлтийг харуулбал:

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Их-Уул сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 06 дүгээр тогтоолд зааснаар Их-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 409.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 494.0 сая төгрөгийг оруулан 84.6 сая төгрөгөөр даван биелүүлж 121,4% ийн биелэлттэй.

Хүснэгт №11. Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Хувь	Зөрүү
Үйл ажиллагааны орлого	18.9	50.4	266.7	31.5
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	180.0	213.5	118.6	33.5

ХХОАТ буцаалт	-30.1	-26.0	86.3	4.1
Хөрөнгийн орлого	34.5	35.0	101.4	0.5
Шууд бус орлого	0.9	1.1	122.2	0.2
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	6.1	5.4	88.5	-0.7
Бууны албан татвар	4.5	4.6	102.2	0.1
Малд ногдуулах албан татвар	96.4	110.0	114	13.6
Улсын тэмдэгтийн хураамж	6.0	4.3	71.7	-1.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.2	0.363	181.5	0.16
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	12.0	11.0	91.7	-1.0
Газрын төлбөр	5.0	5.3	106	0.3
Ойн нөөц ашигласны төлбөр	63.2	56.4	89.2	-6.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.18	0.28	155.6	0.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.945	0.945	100.0	0
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.684	0.685	100.1	0.001
Торгуулийн орлого	6.0	18.6	310	12.6
Түрээсийн орлого	4.0	1.3	32.5	-2.7
Бусад орлого	0.0	0.79	0	0.79
ТӨСВИЙН ОРЛОГО	409.4	494.0	120.6	84.6

Эх сурвалж: Их-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Их-Уул сумын орон нутгийн орлого 84.6 сая төгрөгөөр давж биелэхэд үйл ажиллагааны орлого 31.5 сая төгрөгөөр, Цалин хөлс түүнтэй адилтгах орлого 33.5 сая төгрөгөөр, Хөрөнгийн орлого 0.5 сая төгрөгөөр, Шууд бус орлого 0.2 сая төгрөгөөр, Малд ногдуулах албан татвар 13.6 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 0.16 сая төгрөгөөр, Газрын төлбөр 0.3 сая төгрөгөөр, Ан амьтны нөөц ашигласны төлбөр 0.1 сая төгрөгөөр, Торгуулийн орлого 12.6 сая төгрөгөөр, Бусад орлого 0.79 сая төгрөгөөр давж биелсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогоос 5 нэр төрлийн 12.9 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Орон нутгийн төлөвлөгөө биелээгүй орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 0.7 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 1.7 сая төгрөг, Хог хаягдлын үйлчилгээний хураамж 1.0 сая төгрөг, Ойн нөөц ашигласны төлбөр 6.8 сая төгрөг, Түрээсийн орлого 2.7 сая төгрөг Төсөвт байгууллагын өөрийн орлого 2.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 62.6 сая төгрөгөөр төлөвлөж 55.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 88.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №12: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ	37.3	13.5	-23.8
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	19.0	33.2	14.2
3	Зам ашигласны төлбөр	6.3	8.8	2.5
	Нийт дүн	62.6	55.5	-7.1

Эх сурвалж: Их-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар 14.2 сая төгрөгөөр давж, Зам ашигласны төлбөр 2.5 сая төгрөгөөр давж, ААНОАТ 23.8 сая төгрөгөөр тасарсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 18.1 сая төгрөгөөр төлөвлөж 19.0 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 0.9 сая төгрөгөөр буюу 105 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 18.1 сая төгрөгөөр төлөвлөж 19.0 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 0.9 сая төгрөгөөр буюу 105 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	37.3	13.5	-23.8
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	40.2	33.2	-7.0
3	Агаарын бохирдлын төлбөр	1.0	4.7	3.7
	Нийт дүн	78.5	51.4	-27.1

Эх сурвалж: Их-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 23.8 сая төгрөг, НӨАТ 7.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Орон нутгийн төсвийн санхүүжилт 1,346.4 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 93.8 сая төгрөг, хүүгийн эргэн төлөлт 5.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 130.2 сая төгрөгийн санхүүжилтийн орлого орж, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 4.6 сая төгрөгийг бүрдүүлсэн байна. Хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн эргэн төлөлт төлөвлөснөөс 1 сая төгрөгөөр бага байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,664.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,445.0 сая төгрөгийг урсгал зардалд, 60.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 103.8 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 1,329.9 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 43.6 сая төгрөгийг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 138.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,511.5 сая төгрөг буюу 90.8 хувьтай байгаа нь Сангийн яамнаас тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйтэй холбоотой байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 6.4 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.3 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 7.8 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 9.4 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 5.2 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 93.9 сая төгрөгөөр
- Хөрөнгийн зардал 16.3 сая төгрөг тус тус хэмнэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны гүйцэтгэлийн талаар:

Сумын ИТХ-ын 2021 оны 12 сарын 15-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 18 ажлын санхүүжих эх үүсвэр, зарлагыг 302.7 сая төгрөг байхаар баталсан. Сумын ИТХ-ын 2022 оны 06 сарын 29-ний өдрийн 03 дугаар тогтоолоор 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх жагсаалтаас 2 ажлыг хасаж, 16 ажил хийхээр тодотгол хийгдсэн. Үндэсний их баяр наадмыг 5.0 сая төгрөгөөр зохион байгуулахаар баталсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 211.6 сая төгрөгийн 11 ажлыг бүрэн хийж гүйцэтгэн, 5 ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн гүйцэтгэлийн талаар:

Их-Уул сумын ИТХ-ын 2021 оны 12 дүгээр сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн 2022 оны санхүүжилтийг 143.4 сая төгрөг байхаар баталсан. Сумын ИТХ-ын 2022 оны 06 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 02 дугаар тогтоолоор санхүүжилтийн эх үүсвэрийг 149.1 сая төгрөг болгон тодотгосон. Тайлант онд зээлийн эргэн төлөлтөөс 93.8 сая төгрөг, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс 5.9 сая төгрөгийн орлого

орсон. Тайлант онд нийт 9 хоршоонд 138.0 сая төгрөгийн зээл олгож, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтад 0.9 сая төгрөгийг зарцуулжээ.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

- Нэмэлт санхүүжилтийн дансаар Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардал 3.7 сая төгрөг
- Хүүхэд залуучуудын хөгжлийн газраас Хүүхэд хамгааллын хамтарсан багийн урамшуулал 0.5 сая төгрөг
- БТСГ-аас нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд 1.5 сая төгрөг
- Аймгийн ИТХ-ын хамтарсан багийн дэмжлэг 0.3 төгрөг
- ХХҮГ-ын урамшуулал 0.15 сая төгрөг
- ТӨБЦГ-ын тендерийн хураамж 0.1575 сая төгрөг
- Ахмадын байрны түрээсийн орлого 1.015 сая төгрөг

Сумын 90 жилийн ойн баяраар 2021 оны хандив 65,7 сая төгрөг, ахмадын байрны өрөөний түрээсийн орлого 0.09 сая төгрөг орж ирснийг зориулалтын дагуу зарцуулж үлдэгдэл 0.07 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их-Уул сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 1/74 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,156.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 23.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 18.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,511.6 сая төгрөг буюу 90.8 хувьтай байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 6.4 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.3 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 7.8 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 9.4 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 5.2 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 93.9 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Их-Уул сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд 1 зөрчилд 1 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	1	-	1	-	100

Өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт №13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	37.3	13.5	-23.8
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	40.2	33.2	-7.0
3	Агаарын бохирдлын төлбөр	1.0	4.7	3.7
	Нийт дүн	78.5	51.4	-27.1

Эх сурвалж: Их-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 23.8 сая төгрөг, НӨАТ 7.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Орон нутгийн төсвийн санхүүжилт 1,346.4 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 93.8 сая төгрөг, хүүгийн эргэн төлөлт 5.9 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 130.2 сая төгрөгийн санхүүжилтийн орлого орж, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 4.6 сая төгрөгийг бүрдүүлсэн байна. Хоршоо хөгжүүлэх сангийн хүүгийн эргэн төлөлт төлөвлөснөөс 1 сая төгрөгөөр бага байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,664.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,445.0 сая төгрөгийг урсгал зардалд, 60.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 103.8 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 1,329.9 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 43.6 сая төгрөгийг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 138.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,511.5 сая төгрөг буюу 90.8 хувьтай байгаа нь Сангийн яамнаас тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйтэй холбоотой байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 6.4 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.3 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 7.8 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 9.4 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 5.2 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 93.9 сая төгрөгөөр
- Хөрөнгийн зардал 16.3 сая төгрөг тус тус хэмнэгдсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны гүйцэтгэлийн талаар:

Сумын ИТХ-ын 2021 оны 12 сарын 15-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 18 ажлын санхүүжих эх үүсвэр, зарлагыг 302.7 сая төгрөг байхаар баталсан. Сумын ИТХ-ын 2022 оны 06 сарын 29-ний өдрийн 03 дугаар тогтоолоор 2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх жагсаалтаас 2 ажлыг хасаж, 16 ажил хийхээр тодотгол хийгдсэн. Үндэсний их баяр наадмыг 5.0 сая төгрөгөөр зохион байгуулахаар баталсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 211.6 сая төгрөгийн 11 ажлыг бүрэн хийж гүйцэтгэн, 5 ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн гүйцэтгэлийн талаар:

Их-Уул сумын ИТХ-ын 2021 оны 12 дүгээр сарын 15- ны өдрийн 06 дугаар тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн 2022 оны санхүүжилтийг 143.4 сая төгрөг байхаар баталсан. Сумын ИТХ-ын 2022 оны 06 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 02 дугаар тогтоолоор санхүүжилтийн эх үүсвэрийг 149.1 сая төгрөг болгон тодотгосон. Тайлант онд зээлийн эргэн төлөлтөөс 93.8 сая төгрөг, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс 5.9 сая төгрөгийн орлого

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 67.5 сая төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрсэн. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой 1, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах 1 нийт 2 зөвлөмж хүргүүлж байна

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа төсвийн 2 байгууллага, орон нутгийн өмчит 1 аж ахуйн нэгж, орон нутгийн 2 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ, Их-Уул дулаан ХХК-ийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлын хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан ЗДТГ, Их-Уул дулаан ХХК-ийн санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 73.2 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрсэн. Аудитын хугацаанд 39.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, 33.3 сая төгрөгийн 3 зөвлөмжийг өгсөн байна.

5.1 Төлбөрийн акт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улс, аймаг, сумын орлогын төлөвлөгөөнөөс 8 нэр төрлийн 67.5 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.”хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр биелүүлж ажиллах.

2. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

2.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 73.2 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрсэн. Аудитын хугацаанд 39.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, 33.3 сая төгрөгийн 3 зөвлөмжийг өгсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 4.1 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 1.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 2.8 сая төгрөгийн 2 зөвлөмжийг өгсөн байна.	1						1					
Орон нутгийн орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн	1	67.5					1	67.5				
Дүн	2	67.5					2	67.5				
Харьяа байгууллагуудын зөрчил												
Их-Уул сумын Засаг даргын Тамгын газар	1	0.6					1	0.6				
Их-Уул дулаан ХХК	3	72.6			1	39.9	2	32.7				
Дүн	4	73.2			1	39.9	3	33.3				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 БАТАЛГААЖУУЛСАН:
 АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

С.ГАНСҮХ ОГНОО: